

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын ХАС-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 19 дэх дугаарыг бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийнхээ энэ дугаарын “Судалгаа” хэсэгт эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн асуудал болох умайн лейомиом, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, Монгол улсын төрөлт ирээдүйд доогуур түвшин очих уу, Завхан аймгийн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал зэрэг онол, практикийн хэлцэмж бүхий судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудын үр дүнг танилцуулж байна.

“Сургалт” хэсгийг уншиж, судалснаар тооллого, судалгааны мэдээллийг компьютерт оруулах, засварлах, хүснэгт боловсруулах, мэдээлэл тархаах багц программ CSPro-г ашиглах талаар Та мэдлэгтэй болох бүрэн боломжтой.

Үндэстэн дамнасан хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар эрдэмтэн, судлаачийн дэвшүүлж буй дүгнэлт, саналыг “Үзэл бодол” хэсгээс уншиж танилцахын ялдамд уншигч Та өөрийн үзэл бодлоо манай сэтгүүлээр дамжуулан хуваалцаарай.

Сэтгүүлийнхээ English хэсэгт Яагаад Монголын зарим нутагт цаг агаарын хүчтэй шуурга ихээхэн хохирол учруулсан бэ, Өмнөд Солонгост хууль болон хууль бусаар ажиллаж буй Монголчуудын нөхцөл байдал, Ядуурлыг оролцоонд суурилан үнэлэх нь зэрэг судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудын үр дүнг нийтэллээ.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, манай дараагийн дугаарт өөрийн материалыа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын ХАС-гийн суурин төлөөлөгчийн газарт сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ